

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЦЭНГЭЛ СУМЫН
НУТАГТ ОРШИХ MV-021083 ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛТЭЙ “АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫГ
ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ”
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1. Төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ	ААН нэр: Эс Жи групп Улсын бүртгэлийн дугаар: 9011008070 Регистрийн дугаар: 2621169 Хаяг: Улаанбаатар, Хан-Уул, 2-р хороо, 19 хороолол, чингисийн өргөн чөлөө, 35г, 202 тоот Утас: 86776768, 99234490
ТӨСЛИЙН НЭР	Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт орших MV-021083 тусгай зөвшөөрөлтэй “Алтны үндсэн ордыг далд уурхайн аргаар ашиглах”
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР	Дугаар- MV021083 Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийн үндэслэн Баян-Өлгий аймаг Цэнгэл сум Цэнгэл нэртэй газар орших 2003.63 гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг зөвшөөрч улсын бүртгэлийн 9011008070 тоот гэрчилгээтэй “Эс Жи групп” ХХК-д энэхүү тусгай зөвшөөрлийг 2048.06.05 дуустал хугацаагаар олгосон байна. Хасагдах талбайн хэмжээ 201.07 Га
ТӨСЛИЙН ЗОРИЛГО	Төсөл хэрэгжүүлэгч “Эс Жи групп” ХХК нь Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт орших Цагаан-Овоот уулын алтны үндсэн ордыг Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр ашиглах зорилготой.
УУРХАЙН АШИГЛАЛТЫН СИСТЕМ	Нарийн зузаантай, эгц унатай судлын биетийг олборлох техник эдийн засгийн хувьд хамгийн тохиромжтой систем нь далд уурхайн хоршоолон нураах ашиглалтын системийг сонгосон байна.
ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ НӨӨЦ, ТУШААЛ ДҮГНЭЛТ	2025 оны 08 сарын 20ны өдөр Үндэсний геологийн албаны даргын Н/86 тушаалаар нийт В+С зэрэглэлээр 578,186.60 тн хүдэр 1.8 г/тн дундаж агуулгатай 1,268.6 кг алтны нөөцийг хүлээн авч бүртгэсэн байна. 2025 оны 07 сарын 09 өдөр ЭБМЗ-ийн ХХ-13-02 тоот дүгнэлтээр Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт орших Цагаан-Овоот уулын алтны үндсэн ордын баруун хэсэгт 2024-2025 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуулыг ажлын үр дүнгийн тайланг хэлэлцсэн байна.

2. Төслийн танилцуулга

Монгол улсад “Алт” хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш алтны үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж ирсэн. Хөгжлийн явцад олборлолтын болон баяжуулалтын технологид томоохон хэмжээний дэвшилт гарсан. Мөн алтны салбарын хууль эрх зүй, татварын орчин сайжирснаар алтны тушаалтын болон экспортын орлого тогтвортой өсөж байна. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого” болон “Ашигт малтмалын тухай хууль”-ийн нэмэлт, өөрчлөлтийн зохицуулалтыг алтны салбарын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх нь “Алт 3” хөтөлбөрийг боловсруулан цаашид хэрэгжүүлэх үндэслэл болж байна. Алт

хөтөлбөр нь алтны салбарын ойрын болон дунд хугацааны хөгжлийг хангах, хууль эрх зүйн орчныг тогтвортой байлгах, эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх, алтны үндсэн болон алт агуулсан бусад металлын ордуудыг ашиглах, байгаль орчинд ээлтэй алт олборлох, боловсруулах дэвшилтэд техник технологи нэвтрүүлэх замаар үйлдвэрлэл, түүний үр ашгийг нэмэгдүүлэх, олон улсын өрсөлдөх чадварыг өсгөх, Монгол улсын эдийн засагт оруулах өгөөжийг дээшлүүлэхэд чиглэж байна.

“Эс Жи групп” ХХК нь 1802.56 га талбай бүхий ашигт малтмал ашиглах MV-021083 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд Цагаан-Овоот уулын алтны үндсэн ордыг эзэмшиж байгаа бөгөөд уг тусгай зөвшөөрөл нь 2048 он хүртэл хүчинтэй.

“Эс Жи групп” ХХК нь Цагаан-Овоот уулын алтны үндсэн ордод 2017 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2018 оны 04-р сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж ХХ-03-09 тоот дүгнэлтэд үндэслэж гаргасан Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2018 оны 05-р сарын 11-ний өдрийн н/25 тоот тушаалаар ордын нөөцийг бодитой болон боломжтой В+С зэргээр 10.82 г/тн дундаж агуулгатай, 94.73 мян.тн хүдэр, 1024.74 кг металлын нөөц Улсын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн байна.

2024-2025 онд Цагаан овоот уулын алтны үндсэн ордын Баруун хэсэгт нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэн, баганат өрөмдлөг 5184.6 тууш м, суваг малталт 698 м 3 , керний сорьц 398 ш, ховилон сорьц 126 ш авснаас лабораторийн шинжилгээнд 145 сорьц хамруулж, шинжилгээний дүнгээр ордын нөөцийг бодитой ба боломжтой (В+С) зэрэглэлээр 1268.6 кг-аар тогтоон Улсын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн байна.

3. Төсөл хэрэгжилтийн явц

4. Ашиглаж байгаа техник технологи

Нэвтрэлтийн үеийн ухаж, ачих тээвэрлэх процесс

Далд уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдийг сонгохдоо уурхайн хүчин чадал, ордыг нээх, бэлтгэх схем, ашиглалтын систем, ашигт малтмалын уул геологийн нөхцөлд тохируулан хөрөнгө оруулалтын хэмжээг аль болох бага, аюулгүй ажиллагааны дүрэм зааврыг бүрэн хангасан, бүтээл өндөртэй, ашиглалтын үеийн зардал бага байх нөхцөлүүдийг харгалзан үзэж сонгосон болно. Хэвтээ, налуу амууд болон квершлаг малталт нэвтрэлтийн ачих ажлыг ZWY 60/37L маркийн гинжит ачигчаар ачих бөгөөд хүдрийг мөргөцгөөс XD928 маркийн ачиж зөөвөрлөх машинаар UQ-8 маркийн зөөвөрлөх машинд ачин тээвэрлэнэ.

Хүснэгт 8. ZWY-60/37L маркийн гинжит ачигчийн техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	
1	Ачигчийн марк	-	ZWY-60/37L	

2	Ачаалах хүчин чадал	м³/цаг	60
3	Малгах өргөн	мм	3600
4	Малгах өндөр	мм	3000
5	Ачаалах өндөр	мм	2580
6	Буулга зай	мм	1600
7	Буулгах өндөр	мм	1350
8	Өгсөх чадвар	град	30
9	Явах хурд	км/ц	1.1
10	Цахилгаан хөдөлгүүрийн чадал	кВт	37
11	Овор хэмжээ	мм	6750×1600×1775
12	Жин	кг	7800

Хүснэгт 9. XD928 маркийн ачигчийн техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ
1	Ачигчийн марк	-	XD928
2	Утгуурын багтаамж	м³	0.8
3	Даац	тн	2
4	Буулгах байрлал дахь хамгийн их өндөр	мм	3690±100
5	Ачаалах өндөр	мм	2580
6	Хамгийн бага эргэлтийн радиус	мм	1250
7	Ачих зай	мм	14000
8	Бүрэн ачаалалтай үед өгсөх чадвар	град	30
9	Шанага өргөх хугацаа	сек	≤5
10	Шанага буулгах хугацаа	сек	≤4
11	Хөдөлгүүрийн загвар	-	LR4A3Z-22 CUMMINS 4BTA3.9- C80
12	Овор хэмжээ	мм	5500×1800×1900
13	Жин	кг	7200
14	Дугуйн тоо	ш	4
15	Дугуйн хэмжээ	-	15/70-18



Далд уурхайн тээврийн тоног төхөөрөмж: Уурхайн хүдэр болон хоосон чулуулаг тээвэрлэх тоног төхөөрөмжийг малталт нэвтрэлт, хүдэр олборлолтын хүчин чадалтай уялдуулахаас гадна ачигч машин XD928 маркийн ачигчийн хослолыг харгалзан UQ-8 маркийн автосамосвал сонголоо.

Хүснэгт 10. UQ-8 маркийн автосамосвалын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ
---	-------------	-------------	-------------



1	Автосамосвалын марк	-	UQ-8
2	Тэвшний багтаамж	м ³	4
3	Даац	кг	8000
4	Хамгийн их зүтгэх хүч	kN	≥49
5	Буулгах байрлал дахь хамгийн их өндөр	мм	3690±100
6	Ачаалах өндөр	мм	1750±100
7	Хамгийн бага эргэлтийн радиус	мм	1250
8	Ачих зай	мм	14000
9	Бүрэн ачаалалтай үед өгсөх чадвар	град	12
10	Тэвш өргөх хугацаа	сек	≤35
11	Тэвш буулгах хугацаа	сек	≤25
12	Хөдөлгүүрийн загвар/хүч	кВт	YC4A160-T300/118
13	Овор хэмжээ	мм	4400×1700×1700
14	Жин	кг	5000±150
15	Дугуйн тоо	ш	6

Далд уурхайн тээвэр нь малталт нэвтрэлтийн мөргөцөг, ашиглалтын блокоос хоосон чулуулаг ба хүдрийг “блок (мөргөцөг) - тээврийн штрэк – квершлаг - гол амны хашаа – гол ам” гэсэн маршрутаар зөөвөрлөх, тээвэрлэх үүрэгтэй.

4.3.2 Алтны үндсэн ордын хүдэр баяжуулах технологийн сонголт

“Цагаан-Овоот уул”-ийн алтны үндсэн ордын хүдрийн баяжигдах шинж чанарыг тодорхойлох зорилгоор 2018 онд “Геологийн судалгаа шинжилгээний төв” ТӨҮГ-т технологийн туршилтыг хийсэн. Туршилтаар гравитаци, флотаци, уусгалт, гравитаци – уусгалт хосолсон аргуудаар баяжуулах туршилт хийгдсэнээс гравитаци – уусгалт хосолсон аргаар баяжуулах нь хамгийн оновчтой бөгөөд үр дүн сайтай байна. Тусгай зөвшөөрлийн талбай дээр 2020 онд гравитаци-уусгалт хосолсон технологиор баяжуулах үйлдвэрийг барьж ашиглалтад оруулсан бөгөөд тодотгол төсөлд баяжуулах технологи болон үйлдвэрийн хүчин чадалд өөрчлөлт ороогүй байна.

Уурхайгаас олборлосон хүдрийг баяжуулах үйлдвэрт буталж нунтаглан, том ширхэглэлтэй алт агуулсан хэсгийг төвөөс зугтах хүчний кнельсон сепараторт оруулан баяжуулж баяжмалыг сэгсрэх ширээгээр гүйцээн баяжуулж шлихийн алт агуулсан баяжмалыг гарган авч алт цэвэршүүлэлт, хайлуулалтын хэсэгт цэвэршүүлнэ. Гравитацийн аргаар баяжуулах боломжгүй жижиг ширхэгтэй алтыг натрийн цианидын уусмалаар уусган баяжуулж алтан гулдмай үйлдвэрлэж байна.


Хүснэгт 11. Баяжуулах үйлвэрийн ерөнхий үзүүлэлт

Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал	50.0 мян.тн/жил 277.8 тн/хон 12.9 тн/цаг
Баяжуулах үйлдвэрийн ажиллах хугацаа	180 хоног/жил

Анхдагч хүдрийн ширхэглэл	0-350.0 мм
Хүдэр бэлтгэх технологи	2 шатны бутлалт, 2 шатны нунтаглалт
Нунтаглах хүдрийн ширхэглэл	-0.074мм 85%
Хүдэр боловсруулах технологи	Гравитаци, Уусгалт СИР, Адсорбци, Десорбци (AARL), Электролиз
Хүдрийн агуулга	1.95 гр/тн
Металл авалт	93.5 %
Хаягдлын гаргалт	Хуурай

Баяжуулах үйлдвэрийн бүтэц

Баяжуулах үйлдвэр нь түүхий эд буулган жигдрүүлэх талбай, хүдэр бэлтгэх хэсэг нунтаглан ангилах хэсэг, гравитацаар баяжуулах хэсэг, уусгалт шингээлтийн хэсэг, десорбци-электролизийн хэсэг, хайлуулалтын хэсэг, урвалж бэлтгэх хэсэг, хаягдал усгүйжүүлэх хоргүйжүүлэх хэсэг, хаягдлын овоолго, засвар үйлчилгээний хэсэг, эргэлтийн усны сан, цэвэр усны худаг, ус дамжуулах насос, хяналтын лаборатори зэргээс



Зураг 2. Баяжуулах үйлдвэрийн технологи

бүрдэнэ

5. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин

Төсөл хэрэгжих талбайн физик газарзүй

Төслийн талбай нь Алтайн уулархаг их муж, Монгол Алтайн муж, Монгол Алтайн баруун тойрогт хамаарна.

Алтайн уулархаг их муж нь хойд талаараа Баруун Сибирийн тал, зүүн хойд талаараа Дундад Сибирийн тэгш өндөрлөг, зүүн урд талаараа улсын хилээр зааглагдах бөгөөд өмнөд төгсгөл нь Монгол Алтайн нуруу болно. Монгол улсын хувьд Алтайн уулархаг их муж нь (167,960.4км² буюу 10.7 хувь) Монгол Алтай, Зүүн соён, Тагнын нурууны өндөр уул, хотгорын гэсэн мужийн түвшинд ялгардаг. Тухайлбал, Монгол Алтайн нуруу, Хөвсгөлийн баруун хэсэг, Тагнын нурууны өвөр бэл Увс нуурын хотгор хамрагдана.

Монгол Алтайн муж нь баруун хагаст улсын хилийн дагуу баруун хойноос зүүн урагш чиглэн 800 гаруй км урт сунаж тогтсон уулсын системийг хамаарах ба Говь-Алтайн нуруу болон үргэжилж баруун талдаа Их нуруудын хотгор, өмнө талдаа Баруун хуурайн хотгортой тус тус хиллэнэ. Мужийн нутаг нь Баян-Өлгий аймаг бүтэн, Ховд аймгийн ихэнх, Увс, Говь-Алтай аймгийн баруун хэсгийг хамарч, гол нуруу нь баруун хагаст д.т.д дунджаар 3200-3500м өргөгдөх ба Хүйтэн уул (4374м), Таван богд (4082м), Цаст уул (4193м), Мөнххайрхан (4204м) зэрэг 4000м-ээс дээш өргөгдсөн өндөр уулс олон. Гол нуруу богино, нэлээд өндөр салбаруудтай. Бусад зэрэгцээ нурууд дотогшоо буюу зүүн хойшоо улам намсана. Салбар уулсын орой, хяр хавтгай, хажуу нь нэлээд эгц буюу эртний тэгшрэлийн гадарга геологийн хожуу үед өргөгдсөн байдалтай¹.

Уур амьсгал

Дэлхийн бөмбөрцгийн хойд хагасын сэрүүн өргөрөгт, том эх газрын төв хэсэгт далайгаас алслагдан оршдог тул жилийн дөрвөн улирлын ялгаа тод илэрдэг, температурын хоногийн болон жилийн хэлбэлзэл их, тунадас бага, салхи ихтэй зэрэг нь манай орны уур амьсгалын онцлог шинж юм

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь уур амьсгалын мужлалаар хуурай сэрүүвтэр зунтай мужийн хахир өвөлтэй мужид багтана. Уур амьсгалын нөхцөлийн хувьд хуурайшил 4.1-5.5, дулаан хангамж буюу +10°C-аас дээших агаарын хоногийн дундаж температурын нийлбэр 2500-3000, өвлийн шинж буюу агаарын нэмэх хасах температурын нийлбэрийн зөрөөгөөр –1000.....-500 юм².

Эх газрын эрс тэс, хуурай нөхцөлд хүрээлэн буй орчны гол жолоодогч хүчин зүйл нь хур тунадас болдог³. Чийг дулааны коэффициент хуурай байна. Агаарын дундаж температураар 1-р сард хамгийн хүйтэн ба -17.3°C хүртэл хүйтэрдэг, 7-р сард хамгийн дулаан ба 18.3°C хүртэл халдаг байна. Хур тунадасны нийлбэрээр жилийн дунджаар 108.5 мм. Жилийн дундаж агаарын температур нь 1.6 °C байгаа нь Монгол орны дунджаас⁴ 1.0°C аар дулаан ажээ

Агаарын чанар

¹ Монгол орны физик газарзүй

² Үндэсний атлас 2022он

³ Climate-diagram maps, Berlin 1975

⁴ Монгол орны байгаль орчны төлөв байдал 2022-2023

Цагаан-Овоот уулын алтны үндсэн ордын баруун хэсгийг ашиглах далд уурхайн төслийн талбайд 6 цэгт хийгдсэн хээрийн судалгааны хэмжилт хийхэд хүчилтөрөгч (O₂) ийн хэмжээ хэвийн, Хүхэрт устөрөгч (H₂S) болон Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) илрээгүй. Мөн PM_{2.5}, PM_{10.0} тоосонцрын хэмжээ Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2025 стандартын Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламжийн шаардлага хангаж байгаа бөгөөд дуу чимээний хувьд стандартаас давсан үзүүлэлтгүй.

Геологийн тогтоц ба геоморфологи

Төслийн талбай нь Дунд кембрий-доод ордовикийн Цэнгэл формац (E 2-O 1zn), Дөрөвдөгчийн хурдасууд тархан давхаргазүйн дарааллыг бүрдүүлнэ.

Цагаан овоот уул орд нь Цэнгэл формацийн алевролитийн мэмбэрийн ногоон занар дахь кварцын дэл судал, судлын дагуу босоо чиглэлтэйгээр 70-90о-ийн уналтайгаар байрлана. Цагаан овоот уул орд нь томоохон хэмжээний салбар уулстай эгц өндөр уулс дунд илрүүлэгдсэн. Орд орчмын уулс далайн төвшнөөс дээш 2300-2400 м-ийн хэлбэлзэлтэй бөгөөд уулс хооронд гол ус байхгүй. Цагаан овоот уул ордын хойгуур Ховд гол урсан өнгөрөх бөгөөд ордын өндөрлөгөөс доош 500-600 м-ийн доор урсана.

Цагаан овоот уулын алтны үндсэн орд нь Монгол оны террейний ангиллаар Алтай террейний арлан нумын арын структурт байрлана (Г.Бадарч, 2002). Монгол орны 1:1'000'000 масштабтай тектоникийн зурагт ялгасан (О.Төмөртоогоо, 2002) Монгол Алтайн ороген бүслүүрийн Алтайн турбидитэт, Өлгийн далайн царцдаст терренүүдийн зангилаа хэсэгт оршино. Орд нь Толбо нуурын гүний хагарлын бүсд оршдог бөгөөд уг хагарал талбайн төв хэсгээр баруун хойш 320о-ийн чиглэлтэй дайран өнгөрдөг. Толбо нуурын гүний хагарлын баруун урд талбай нь Алтайн турбидитэд террейн, хагарлын зүүн хойд хэсгийн талбай нь Өлгийн далайн царцдаст террейнүүдэд хамаарна.

Судалгааны талбай нь ерөнхийдөө Төв Азийн эх газрын өргөгдлийн Монгол Алтайн нурууны төв хэсэгт Е.В.Девяткин, Ш.Цэгмид нарын хийсэн геоморфологийн мужлалаар Монгол Алтайн уулт тогтолцоонд хамаарагдана. Судалгааны талбай орчмын хамгийн өндөр цэг болох 3442.2 м өндөрлөгтэй Баян уулаас гадна Хар уул (2907.1 м) зэрэг 2400-3400 м өндөртэй уулсууд байдаг. Эдгээр уулсын орой нь мөстлөгийн улмаас тэгширсэн мөлгөрдүү байхад, дунд өндөрлөг уулсын хяр, орой нь зарим нь хурц шовх дэл хадархаг, уулсын хажуу нь эгц налуутай, баруунаас зүүн тийшлэх тусам өндөр нь аажим намсах ерөнхий зүй тогтол ажиглагдах ба, хөндий гуу жалгуудаар ихээхэн хэрчигдсэн байдаг⁵.

Гадаргын болон газрын доорх ус

⁵ Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт орших Цагаан-Овоот уулын алтны үндсэн ордын баруун хэсгийг ашиглах далд уурхайн техник, эдийн засгийн үндэслэл 2025

Шинжилгээний дүнгээр 2019 химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн 2-р төрлийн чанарын хувьд нэн цэнгэг, маш зөөлөн ус байна. Шижилсэн үзүүлэлт нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгэн MNS 0900:2018”, “Усан орчны чанар. Ерөнхий шаардлага MNS 4586:2024” стандартын шаардлагуудыг хангаж байна.

Цагаан-Овоот уулын үндсэн ордын баруун хэсгийг ашиглах далд уурхайн ойр байрлах гадаргын болон худгийн уснаас дээж авч шинжлүүлсэн. TSO-01US дугаартай дээж нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгэн MNS 0900:2018” стандартын шаардлагыг хангасан, TSO-02US дугаартай ус нь “Усан орчны чанар. Ерөнхий шаардлага MNS 4586:2024” стандарттай харьцуулахад 2-р зэргийн ус байна. Уст цэгүүдийн дээжийн хүнд металлын шинжилгээг “Алс” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид тодорхойлуулсан ба “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018”, “Усан орчны чанар. Ерөнхий шаардлага MNS 4586:2024”, “Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх хэмжээ MNS 6148:2010” стандартуудтай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлт илрээгүй.

Хөрсөн бүрхэвч

Төслийн талбай нь Монгол орны хөрс газарзүйн мужлалаар Говийн их мужийн Монгол Алтайн муж, Монгол Алтайн тойрогт хамаарах бөгөөд хөрсний тархалтаар уулын хөрс, голын татмын хөрс талбайн хэмжээнд зонхилон тархсан. Хээрийн хэмжилт хийсэн цэгүүдэд Цайвар бор, Цайвар шаргал, Цайвар саарал хөрсний дэд хэв шинжүүдэд багтах элсэнцэр, нарийн элс төрлийн хөрсний тархалттай.

Шинжилгээний дүнгээр 2019 онд хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, зүсэлт 1,2 бага зэрэг карбонаттай, ялзмагийн агууламжаар маш бага, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар маш бага, механик бүрэлдэхүүн элс. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин маш бага байна.

Хөрсний А үе давхаргад хөрсний урвалын орчин 8.03-8.59 дунд шүлтлэг-хүчтэй шүлтлэг, 0-2.67% сул карбонатжсан-дунд зэрэг карбонатжсан, 0.478-4.009% маш бага-дунд зэрэг ялзмагтай, 0.116-4.1dS/m сул давсархаг-хэт их давсархаг. Хөрсний В үе давхаргад хөрсний урвалын орчин 8.38-8.71 дунд шүлтлэг-хүчтэй шүлтлэг, 0-3.03% сул карбонатжсан-дунд зэрэг карбонатжсан,, 0.27-2.205% маш бага-дунд зэрэг ялзмагтай, 0.39-9.18dS/m дунд давсархаг-хэт их давсархаг.Хөрсний хөдөлгөөнт элементүүд (К, Р): Хөдөлгөөнт фосфорын агууламж 1.5 мг/100гр-аас бага бол хангамжийн зэргийн хувьд бага, 1.5мг/мг-3 бол дунд зэрэг хангамжтай гэж үздэг бөгөөд талбайн хөрсний хөдөлгөөнт фосфорын агууламж 0.39-9.79мг/100 гр байгаа нь хангамжийн зэргийн хувьд бага-дунд зэрэг ангилалд хамаарахаар байна. Харин Хөдөлгөөнт калийн агууламж талбайн хөрсний нийт үе давхаргад 19.1-76мг/100гр буюу хангамжийн зэргийн хувьд бага ангилалд

хамаарахаар байна. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага зэргээс дунд зэрэг байна.

Ургамлан нөмрөг

Төслийн талбай орчим өвлийн улиралд ургамал бүлгэмдэл хагдарсан ба хаврын улиралд 10 овгийн, 18 төрөлд багтах, 23 зүйлийн ургамал тэмдэглэгдсэн байна⁶. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын хүрээнд 20 овгийн, 39 төрөлд хамаарагдах 48 зүйл ургамал бүртгэгдсэн бөгөөд бид судалгаанд iNaturalist (2026) олон нийтийн оролцоонд суурилсан биологийн олон янз байдлын мэдээллийн сангаас авч ашигласан. Төслийн нөлөөлөлд өртөх боломжтой бүс нутагт 3 зүйлийн завсрын унаган, 1 зүйл ховор, 0 зүйл үлдвэр, мөн Монгол Улсын Улаан номд бүртгэлтэй 2 зүйл, Дэлхийн байгаль хамгаалах холбооны (IUCN) EN-2, Устаж болзошгүй- 0 зүйл, VU – Эмзэг- 0 зүйл, NT – Ховордож болзошгүй -0 зүйл бүртгэгдсэн байна.

Амьтны аймаг

Бидний судалгаа цаг хугацааны хувьд өвлийн ид хүйтэн үед таарсан бөгөөд зарим зүйлийн мэрэгч, нүүдлийн шувууд, улирлын давтамжтай нүүдэллэдэг болон ичсэн хөхтөн амьтдыг тодорхойлох боломжгүй учир төслийн талбай орчимд хийгдсэн судалгаануудыг ашиглан төслийн талбай орчимд тархаж болзошгүй. Бүс нутгийн хэмжээнд үнэлснээр “устаж болзошгүй -EN” 2 зүйл буюу Цоохор ирвэс, Аргаль “ховордож болзошгүй-NT”-6 зүйл буюу Усч зэрэлзгэнэ, Үнэг, Саарал чоно, Мануул, Шилүүс, Зэрлэг гахай, “эмзэг”-VU 1 зүйл буюу ойн булга тус тус байна

6. Нийгэм-эдийн засгийн төлөв байдал

Эдийн засаг

Орон нутгийн төсвийн нийт орлого 2026 оны 01 дүгээр сарын байдлаар 1 956.7 сая төгрөгт хүрч, төлөвлөгөөг 72.1 (3.8%) сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Төсвийн нийт орлогын төлөвлөгөө 3.8 хувиар давуулан биелэгдэхэд хувь хүний орлогын албан татварын орлого 110.8 (9.6%) сая төгрөг, хөрөнгийн албан татварын орлого 53.4 (53.3%) сая төгрөг, бусад татвар, төлбөр, хураамжийн орлого 2.0 (6.1%) сая төгрөгөөр төлөвлөгөөг илүү биелүүлсэн нь нөлөөлсөн байна. Харин 2026 оны 01 дүгээр сард төсвийн нийт орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 428.0 (17.9%) сая төгрөгөөр буурахад төвлөрсөн төсвийн орлого 79.3 (21.4%) сая төгрөг, хувь хүний орлогын албан татвар 286.0 (18.4%) сая төгрөг, бусад татвар, төлбөр, хураамж 6.5 (16.1%) сая төгрөг, ААНОАТ-ын хуваарилал 6.9 (9.4%) сая төгрөг, нийтлэг татварын бус орлого 108.8 (49.1%) сая төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүн ам

⁶ Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт орших Эс Жи Групп ХХК-ийн MV-021083 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Цагаан-Овоот уул нэртэй ордын төслийн талбайн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан, 2019он

2025 оны байдлаар Баруун бүсэд 79,216 малчин байгаа бөгөөд үүнээс Баян-Өлгий аймагт 16,032, Цэнгэл суманд 2,691, харин 7-р баг Долоон гатлагад 205 малчин байна. Баян-Өлгий аймаг нь Баруун бүсийн малчдын 20.2 хувийг, Цэнгэл сум нь аймгийн малчдын 16.8 хувийг, 7-р баг нь сумын малчдын 7.6 хувийг тус тус эзэлж байна.

Дундаж наслалт

1992–2024 оны хооронд дундаж наслалт өсөх хандлагатай байна. 1990-ээд оны эхээр дундаж наслалт ойролцоогоор 65 нас байсан бол 2000 он хүртэл бага зэрэг хэлбэлзсэн байна. Харин 2005 оноос хойш тогтвортой өсөж, 2015 оноос 73 нас давсан үзүүлэлтэд хүрчээ. Сүүлийн жилүүдэд өсөлт үргэлжилсээр 2024 онд дунджаар 76 нас болж хамгийн өндөр түвшинд хүрсэн байна. Иймээс сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд дундаж наслалт нийтдээ 10 гаруй насаар нэмэгдсэн бөгөөд энэ нь хүн амын эрүүл мэнд, амьдралын нөхцөл сайжирсныг харуулж байна.

Төрөл, нас баралт, ердийн цэвэр өсөлт

2026 оны 01 дүгээр сарын байдлаар 1 000 хүнд ногдох төрөлт 1.7 болж, өмнөх оны мөн үеэс 0.1 нэгжээр буурсан, 1 000 хүнд ногдох нас баралт 0.3 болж, өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Хүн амын ердийн цэвэр өсөлтийн коэффициент (ХАЕЦӨК) 1.4 болсон нь 1 000 хүн тутамдаа 1 хүнээр нэмэгдэж байна.

Эрүүл мэндийн өнөөгийн түвшин

Аймгийн хэмжээнд 2026 оны 01 дүгээр сарын байдлаар 185 эх амаржиж, 187 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 18 хүн (8.9%)-ээр, төрсөн хүүхэд 20 (9.7%)-ээр тус тус буурсан байна. 0-1 насны хүүхдийн 3 эндэгдэл бүртгэгдсэн нь өмнөх оноос 1 хүүхдээр, 1-5 насны хүүхдийн эндэгдэл бүртгэгдээгүй байна. Амбулаториор давхардсан тоогоор 44.8 мянган хүнд үзлэг хийгдэж, 2.2 мянган хүн хэвтэн эмчлүүлэв. Халдварт өвчнөөр өвчлөгчид 30 болж, өмнөх оны мөн үеэс 5 хүн (20.0%)-ээр өссөн байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн дунд салхин цэцэг өвчнөөр өвчилсөн хүмүүс 93.3 хувь эзэлж байна.

Хөдөлмөр эрхлэлт

2026 оны 01 дүгээр сарын байдлаар аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүй иргэний тоо 530 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 965(64.5%) хүнээр буурсан байна. Ажлын байрны захиалга 23 ирснээс, 1 иргэн зуучлагдан ажилд орсон байна.

Мал аж ахуй

2025 оны байдлаар малын тоо Баруун бүс 13777.2 мян.тол, Баян-Өлгий 1919 мян.тол, Цэнгэл сум 258.9 мян.тол, 7-р баг 15.3 мян.тол малтай байна. 1970-2025 оны хооронд Баруун бүсийн малын тоо толгой 52.6%, Баян-Өлгий аймаг 56%, Цэнгэл сум 53%, харин 2012-2025 оны хооронд Цэнгэл сумын 7-р багын малын тоо толгой 14.3% өссөн байна.

7.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Ажлын тоо хэмжээ, давтамж	2026он	Нийт дүн	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1. Агаарын чанар							
1	Далд уурхайн өрөмдлөг, тэсэлгээ, олборлолт, овоолго	Агааржуулалтын системийг зааврын дагуу ажиллуулах	Далд уурхайн хэсэг	Өдөр тутам	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль – 27.1
2		Дизель техникт тогтмол засвар үйлчилгээ хийх ба хуваарь гаргах	Далд уурхайн хэсэг	Өдөр тутам	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоо явуулах журам – 2.1, 2.2, 3.7, 4.3
3		Дизель техникт бага хүхэртэй түлш хэрэглэх	Далд уурхайн хэсэг	Өдөр тутам	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Агаарын тухай хууль 3.1.10, 21.5
4		Тэсэлгээний дараа буцаж орох хугацааг хийн хэмжилтэд үндэслэн тогтоох	Далд уурхайн хэсэг	Өдөр тутам	Хий хэмжигч багажны зардлыг орчны хяналт-шинжилгээний зардалд тусгав.	-	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль – 27.1, 28.1.6, 28.1.8, 28.1.14
5		Тээврийн хэрэгслийн замыг засаж сайжруулах, сайжруулсан шороон зам тавих	Далд уурхайн хэсэг	Өдөр тутам	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 28-р дугаар зүйл

6		Далд уурхайд ажиллаж буй хүмүүст тоосжилтоос хамгаалах маск олгох	Далд уурхайн хэсэг	Өдөр тутам	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 15.1, 15.2, 15.3, 15.4
7		Ачиж буулгах цэгүүдэд тоос дарах, чийглэх	Далд уурхайн хэсэг	Дулааны улиралд 5 сарын хугацаанд нийт 45 удаа усалгаа хийгдэнэ	5,000.0	5,000.0	Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрэм 483, 502-р заалт
8		Ачиж буулгах цэгүүдэд тоос дарах, чийглэх манан үүсгэгч байршуулах	Далд уурхайн хэсэг	1 удаа худалдан авч 5 жилийн хугацаанд ашиглана	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрэм 185-р заалт
9	Хүдэр хүлээн авах талбай, тэжээгүүр, бутлах хэсэг	Хүдэр хүлээн авах хэсэгт мананцаруулах систем суурилуулах	Хүдэр хүлээн авах талбай	1 удаа худалдан авч 5 жилийн хугацаанд ашиглана	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
10		Тээврийн хурдад хязгаар тогтоож, 20км/цаг-аас илүүгүй хурдтай зорчих	Далд уурхайгаас хүдэр хүлээн авах талбай хүртэл	Өдөр тутам	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Замын хөдөлгөөний дүрэм
11		Далд уурхайгаас ирсэн хүдрийг бутлах үед тоосжилт үүсэх тул баяжуулах	Бутлуурын хэсэг	Сар бүр солино	5,000.0	5,000.0	Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн

		үйлдвэр, тээрмийн тэжээгүүр дээр вентилятор ажиллуулах, хэвийн үйл ажиллагааг хангаж, тоосны хүүдийг тогтмол солих					аюулгүй ажиллагааны дүрэм 134-138-р заалт
12		Үйл ажиллагааны түвшинд бутлуур, конвейер, шигшүүр, хүдэр нөөцлөх бункерт үзлэгийг тогтмол хийх	Бутлуурын хэсэг	Өдөр тутам	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Ашигт малмталыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрэм 78,84-р заалт
13	Гравитацийн баяжуулалт	Тунаах машин, сэгсэрдэг ширээнд техникийн үзлэг тогтмол хийж эвдрэл гэмтэл үүдэн халих, асгарахаас урьдчилан сэргийлэх	Гравитаци йн баяжуулалт ийн хэсэг	Өдөр тутам	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Ашигт малмталыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрэм 78,84-р заалт
14	Нүүрсэнд шингээх хэсэг /адсорбцийн хэсэг/	Асгаралт, алдагдал цэвэрлэх багц	Нүүрсэнд шингээх хэсэг /адсорбцийн хэсэг/	1 удаа худалдан авч өдөр тутам ашиглах	1600	1600	Химийн хорт болон аюулгүй бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 2.1.8-р заалт
15		Шугам, насос, холболтын битүүмжийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах	Нүүрсэнд шингээх хэсэг /адсорбцийн хэсэг/	Өдөр тутам	5,000.0	5,000.0	Ашигт малмталыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй

							ажиллагааны дүрэм 335-р заалт
16		pH орчин зэргийг тогтмол хянах	Нүүрсэнд шингээх хэсэг /адсорбций н хэсэг/	1 удаа худалдан авч өдөр тутам ашиглах	300	300	Ашигт малмталыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрэм 269-р заалт
17		HCN мэдрэгч	Нүүрсэнд шингээх хэсэг /адсорбций н хэсэг/	1 удаа худалдан авч өдөр тутам ашиглах	4,000	4,000	Ашигт малмталыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрэм 256-р заалт
18	Натрийн циан найруулах хэсэг	Агааржуулалт, битүүмжлэл, асгаралт алдагдалд тогтмол хяналт тавьж, зөрчил илэрсэн үед шуурхай арга хэмжээ авах дотоод журам, сургалт, ослын бэлэн байдлыг тогтмол хангана.	Натрийн циан найруулах хэсэг	Өдөр тутам	5,000	5,000	Химийн хорт болон аюултөй бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 2.1.5-р заалт
19		HCN мэдрэгч	Натрийн циан найруулах хэсэг	1 удаа худалдан авч өдөр тутам ашиглах	4,000	4,000	Ашигт малмталыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрэм

							256-р заалт
20		Асгаралт, алдагдал цэвэрлэх багц	Натрийн циан найруулах хэсэг	1 удаа худалдан авч өдөр тутам ашиглах	1600	1600	Химийн хорт болон аюулгүй бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 2.1.8
21	Нүүрснээс ялгах хэсэг /Дисорбци/	Дамжуулах хоолой, насос, холболтын битүүмжлэл, бүрэн бүтэн байдлыг шалгах, алдагдлыг шуурхай илрүүлж арилгах	Нүүрснээс ялгах хэсэг /Дисорбци, электролиз, хайлуулах/	Өдөр тутам	5,000	5,000	Ашигт малмталыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрэм 335-р заалт
22		HCN үүсэх эрсдэлтэй цэгүүдэд мэдрэгч, дохиоллын систем байршуулах	Нүүрснээс ялгах хэсэг /Дисорбци, электролиз, хайлуулах	1 удаа худалдан авч өдөр тутам ашиглах	4,000	4,000	Ашигт малмталыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрэм 256-р заалт
23		Асгаралт, алдагдал цэвэрлэх багц	Нүүрснээс ялгах хэсэг /Дисорбци, электролиз, хайлуулах	1 удаа худалдан авч өдөр тутам ашиглах	1600	1600	Химийн хорт болон аюулгүй бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 2.1.8
24	Химийн бодис хадгалах агуулах	Бүх химийн бодист шошго, хаягжуулалт хийх	Химийн бодис хадгалах агуулах	Өдөр тутам	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 10.3-р заалт

25		Асгаралтын үеийн аюулгүй ажиллагааны журам хэрэгжүүлж ажиллах	Химийн бодис хадгалах агуулах	Өдөр тутам	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 8.2-р заалт
26		Агуулахад зөвхөн сургалтад хамрагдсан болон агуулах хариуцсан ИТА-нууд харьцаж ажиллах	Химийн бодис хадгалах агуулах	Өдөр тутам	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 17.3-р заалт
27		Дээжлэлтийг зааврын дагуу гүйцэтгэх	Химийн бодис хадгалах агуулах	Өдөр тутам	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 18.2.1-р заалт
28	Тээврийн хэрэгсэл, зам	Урьдчилан сэргийлэх засвар, техникийн үзлэг, хөдөлгүүрийн тохируулга	Авто бааз	Жил бүр	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль 22.6-р заалт
29		Шороон замын тоосжилтыг бууруулах, тоосжилт дарах бодис ашиглах	Уурхайн сайжруулсан зам талбайн хүрээнд	Жилд 2 удаа	2,800	2,800	Агаарын тухай хууль 20.1-р заалт
30	Уурын зуух	Яндангийн хий болон орчны агаарт ялгарч буй хий зэрэгт усан шүүлтүүрийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах, засвар үйлчилгээг тогтмол хийх	Уурын зуух	Жил бүр 1 удаа	1,000	1,000	Агаарын тухай хууль 20.2-р заалт
2. Газрын хэвлий							
31	Далд уурхайн нэвтрэлт,	Уурхайн процессийг явуулахдаа ТЭЗҮ, УАТ-г баримтлаж	Далд уурхайн хэсэг	Өдөр тутам	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Ашигт малтмалын тухай хууль 35.3.2-р заалт

	өрөмдлөг, тэсэлгээ,	ажиллана					
32	Хүдэр олборлолт, овоолго,	Олборлолтын дараалал, нээлттэй орон зайн хэмжээг хянах	Далд уурхайн хэсэг	Өдөр тутам	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Газрын хэвлийн тухай хууль 31.1-р заалт
33		Нуралтаас хамгаалах бэхэлгээг хийхдээ стандартыг баримтлаж ажиллах	Далд уурхайн хэсэг	Өдөр тутам	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 18.2.1
34	Хүдэр тээвэрлэх зам	Хүдэр болон агуулагч чулуулаг тээвэрлэх сайжруулсан шороон зам тавих ажлын хүрээнд өндөр уултай хэсгүүдэд сэтгэлгээ хийнэ. Тус ажлыг гүйцэтгэхдээ ТЭЗҮ, зураг төслийн дагуу гүйцэтгэх	Далд уурхайгаас баяжуулах үйлдвэр хүрэх хэсэг	Төслийн бүтээн байгуулалтын хүрээнд	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Авто замын тухай хууль 20.5-р заалт
35	Баяжуулах үйлдвэр	Баяжуулах үйлдвэрт химийн бодис ашиглалт, баяжуулах, алт ялгах явцад асгаралт үүсэж, хөрс, усаар дамжин газрын хэвлий бохирдохоос сэргийлэх	Баяжуулах үйлдвэр	Өдөр тутам	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 8.1-р заалт
36		БҮ-т ашиглагдах химийн бодисыг хүлээн авах, хадгалах, үйлдвэрийн бүсэд тээвэрлэх, ашиглах журам боловсруулж, хэрэгжүүлж ажиллах	Химийн бодис хадгалах агуулах, Баяжуулах үйлдвэр	Өдөр тутам	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 8.2-р заалт

3. Хөрсөн бүрхэвч							
37	Далд уурхай	Далд уурхайн хэсэгт нэмэлтээр хийгдэх зам, талбайн шимт хөрс хуулж, хадгалах стандартын дагуу хадгалах	Далд уурхайн хэсэг	Ажил гүйцэтгэх эхний шатанд	4,000	4,000	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль 6.1.4-р заалт
38	Уурхайн бэлтгэл ажлын үед хөрсөн орчинд сөрөг нөлөөлөл үүсэх	Замын нэгдсэн маршрут гаргаж ажлын явцад ашиглах зам талбай бэлтгэх, тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Далд уурхайн хэсэг	Ажил гүйцэтгэх эхний шатанд	1000	1000	Авто замын тухай хууль 20.5-р заалт
39	Машин механизмын үйл ажиллагаа	Шатах тослох материал асгарч хөрсөнд нэвчихээс сэргийлж агуулах засварын талбайн шалыг цементлэх, /Машин механизмын засвар үйлчилгээг зөвхөн зориулалтын засварын байр талбайд хийж гүйцэтгэх/	Автобааз	Тус ажлыг шинээр хийж гүйцэтгэх	Үндсэн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль 11.4.3-р заалт
40	Химийн бодис хөрсөн орчинд асгаралт, бохирдол үүсэх	Химийн бодис тээвэрлэлт, хадгалах, ашиглах үед аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөж асгаралт үүсэж хөрсөн орчныг	Химийн бодис хадгалах агуулах, Баяжуулах үйлдвэр	Өдөр тутам	5,000	5,000	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 13.3-р заалт

		бохирдуулах магадлалтай. Иймд асгарсан үед авах арга хэмжээний төлөвлөгөө зайлшгүй боловсруулж, хэрэгжүүлэн, шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, материал, хувийн хамгаалах хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллана					
41	Хаягдлын далан	Хаягдлын далангийн өргөтгөлийн ажлын талбайн шимт хөрс хуулж, хадгалах	Хаягдлын далан	Ажил гүйцэтгэх эхний шатанд	4000	4000	Газрын тухай хууль 50.1.1-р заалт
42		Хаягдлын далангийн геомембран доторлогоо, хийцийн тогтворжилтод хяналт тавьж ажиллах	Хаягдлын далан	Өдөр тутамд	3,000	3,000	Барилгын тухай хууль 11.1.3
43		Хаягдлын далангийн үер ус зайлуулах суваг шуудуу, хамгаалалтын бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж, сэргээн засах ажлыг жил бүр зохион байгуулах	Хаягдлын далан	Жил бүр	3,000	3,000	Барилгын тухай хууль 46.1.9-заалт
4. Ургамлан нөмрөг							
44	Далд уурхай, баяжуулах үйлдвэрийн үйл	Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах боломжтой ургамлын нөөцийн судалгааг,	Төслийн хүрээнд	Төслийн боломжит хугацаанд	2000	2000	Байгалийн ургамлын тухай хууль 7-р зүйл

	ажиллагаа ургамлан нөмрөгт сөргөөр нөлөөлөх	ховор ургамлын тархалтын байршлыг нарийвчлан тогтоох мэргэжлийн судлаачаар гүйцэтгүүлэх					
45		Биологийн нөхөн сэргээлтэд зориулан цуглуулсан ургамлын үрийн санг хадгалах, мэдээллийн сан үүсгэн хамгаалах	Төслийн хүрээнд	Төслийн эхний шатанд	2000	2000	Байгалийн ургамлын тухай хууль 5-р зүйл
46		Төслийн талбай орчмын ургамалжлын судалгаагаар тогтоосон ургамлуудын үрийг цуглуулах	Төслийн хүрээнд	Төслийн дунд, дуусах хугацаанд	6000	6000	Байгалийн ургамлын тухай хууль 16-р зүйл
47		Нөөцийн судалгаагаар тогтоогдсон нөхөн сэргээлтэд ашиглагдах ургамлыг тарьж ургуулах туршилт судалгаа хийх, ховор болон хамгааллын статустай ургамлын талаар ажилчдад мэдээлэл олгох, төслийн үйл ажиллагаанд өртөх эрсдэлтэй гэж үзвэл шилжүүлэн суулгах, хашиж хамгаалах зэрэг хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх	Төслийн хүрээнд	Төслийн дунд хугацаанд	2000	2000	Байгалийн ургамлын тухай хууль 2-дугаар зүйлийн 4дэх заалт

